

**ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС БОЛОН
МОНГОЛ УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
“ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ” ТӨСЛИЙН II ҮЕ ШАТНЫ
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2016 оны эцсийн байдлаар)**

2017 оны 03 дугаар сарын 30

№	Хөтөлбөр/ төслийн агуулга	Гүйцэтгэл			
1.	Төслийн нэр: Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл MNG16-01	Төслийн үндсэн /хөгжлийн/ зорилго: Хөдөө аж ахуйн мэргэжлийн яриа хэлэлцээ болон тогтвортой хөдөө аж ахуйг дэмжсэн үйл ажиллагаанууд нь Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг хөхиүлэн дэмжинэ.			
	Баталсан шийдвэр, огноо, дугаар:	ХБНГУ-ын Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яам болон МУ-ын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хооронд 2007 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан хамтран ажиллах мэдэгдэл; ХХХААЯ болон ХХААХҮЯ хооронд 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан “Герман-Монголын хамтын ажиллагааны – Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг хэрэгжүүлэх хамтарсан мэдэгдэл			
2.	Санхүүгийн эх үүсвэр	ХБНГУ-ын Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яамны буцалтгүй тусламж			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Төслийг дэмжигч байгууллага: Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам (ГФА Консалтинг групп яамыг төлөөлж төслийн ерөнхий захиалагчаар ажилладаг) Гол түншлэгч байгууллага: Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хэрэгжүүлэгч байгууллага: Консерциум: ИАК Аграр Консалтинг ХХК (гол хэрэгжүүлэгч), АФС Консултанте Интернэйшнл ХХК, ДОЙЛА Нийнбург ХХК, ДЛЖ Интернэйшнл ХХК зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна. Хугацаа: 2016 оны 4 сар - 2018 оны 12 сар			
4.	Төслийн зорилго, шалгуур үзүүлэлт	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улс хоорондын хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааг тогтвортой хөдөө аж ахуйн сэдвүүдээр эрчимжүүлэхэд тус төслийн Шалгуур үзүүлэлт: <ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомжууд нь олон улсад мөрдөгддөг дүрэм журам, стандартуудад тулгуурласан байна. Монгол Улс, ХБНГУ-ын хөдөө аж ахуйн салбар дахь мэргэжлийн солилцоо нь тогтмол үргэлжилнэ. 			
5.	Зардал	Төслийн нийт төсөв 1.158.772 евро			
		Тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгө	303.600 евро /2016.04-2016.12/		
		Үүнд:	Төсөв /евро/	Гүйцэтгэл	Хувь
		Зөвлөх үйлчилгээ, томилолтын зардал (Гадаад, дотоодын богино хугацааны мэргэжилтэнүүд)	169.050	169.050	100
		Хурал, зөвлөгөөн, семинар, туршлага солилцох аялал, талбайн өдөрлөг, сургалт, сургалтын материал, ... г.м. зардал	73.620	73.620	100
	Захиргаа, аж ахуйн зардал (Оффис, төслийн автомашин, холбоо, сонин хэвлэл... г.м.)	60.930	60.930	100	
6.	Төслийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ.			
	Үр дүн 1. Сонгосон сэдвүүдээр хийх хөдөө аж ахуйн мэргэжлийн яриа, хэлэлцээ нь	2016 оны 6 сарын 17-нд Төслийн II үе шатны нээлтийн уулзалтыг зохион байгуулав. Тус уулзалтаар төслийн үндсэн чиглэлүүдийг баталгаажуулж, а) үр сорт, үрийн аж			

<p>тогтвортой хөдөө аж ахуйд чиглэсэн шинэчлэлийг идэвхитэй дэмжинэ.</p> <p><u>Шалгуур үзүүлэлтүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуйн холбогдох сэдвүүдийг жил бүр шинэчлэн батлана. • Тогтвортой хөдөө аж ахуйн сэдвүүдээрх яриа хэлэлцээн нь мэргэжлийн хурал зөвлөгөөн, сургалт семинар, танилцах аяллын хүрээнд өрнөнө. • Төслийн үндсэн 3 чиглэлээр боловсруулсан загвар, концепц болон шийдлүүдийг холбогдох ажлын хэсэг/зөвлөх баг нь шийдвэр гаргах явцдаа ашиглана. 	<p>ахуй, б) тогтвортой хөрс ашиглалт, хамгаалал, в) хөдөө аж ахуйн эрсдлийн менежмент, тариалангийн даатгал зэрэг чиглэлүүдээр ажиллахаар тогтсон.</p> <p>Төслийн II үе шатны Удирдах хорооны анхны хурлыг ХБНГУ-ын Ханновер хотноо 2016 оны 11 сарын 15-нд зохион байгуулсан бөгөөд тус хурлаар 2016 онд хийсэн ажлуудтай танилцаж, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.</p> <p>2016 оны 5 сарын 28-аас 6 сарын 4-ний хооронд ХБНГУ-д “Таримал ургамлын үр, сорт, үрийн аж ахуй”-н чиглэлээр танилцах аялал зохион байгуулав. Тус аяллын бүрэлдэхүүнд ХХААХҮЯ, УГТХ-ийн холбогдох мэргэжилтэнүүд хамрагдан Холбооны Сортын Агентлагийн үйл ажиллагаатай танилцаж, хамтын ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>Түүнчлэн олон улсын түвшинд үйл ажиллагаа эрхэлдэг Германы даатгалын болон давхар даатгалын компаниудын төлөөлөлтэй уулзаж, Тариалангийн даатгалын хуулийг шинэчлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.</p> <p>2016 оны 11 сарын 12-19-ний өдрүүдэд “Тариалангийн даатгал болон малын халдварт өвчинтэй тэмцэх арга замууд” сэдвээр хоёрдахь танилцах аяллыг зохион байгуулсан.</p> <p>2016 оны 6 сараас Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж, гадаад улс, орнуудын туршлагуудыг судалж, хуулийн төсөлд олон улсын зөвлөхийн зөвлөмж авч ажилласан.</p> <p>2016 оны 5-6 сард “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн хүрээнд ямар үр дүн хүлээгдэж байгаа, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг судлах суурь судалгааг гүйцэтгэсэн. Тус судалгааны тайлан төслийн цаашдын үйл ажиллагаанд чухал хэрэглэгдэхүүн болно.</p> <p>ХШҮ-90 %</p>
<p>Үр дүн 2. Монгол Улсад зохион байгуулагдаж буй мэргэжлийн болон мэдээллийн зорилтот арга хэмжээнүүдэд хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн мэдлэг түгээгчдийг хамруулан, тогтвортой хөдөө аж ахуй хөгжүүлэх сонирхолыг бэхжүүлнэ.</p> <p><u>Шалгуур үзүүлэлтүүд</u></p> <ul style="list-style-type: none"> • Тогтвортой хөдөө аж ахуйн үзэл баримтлал/ хандлага нь олон нийтийн дунд түгээмэл хэлэлцэгдэх (жилд 2 нийтлэл мэргэжлийн сонин сэтгүүлд гаргах эсвэл зурагт хуудас хэвлэх) • ХАА-н бодлогын сэдвүүдээр олон нийтийг хамарсан мэргэжлийн болон мэдээллийн арга хэмжээнүүдийг зохион 	<p>Төслийн II үе шатны зорилго, үндсэн чиглэлүүд болон Герман улсын таримал ургамлын үрийн аж ахуйн талаар олон нийтэд “Шинэ тариаланч” сэтгүүлээр дамжуулан мэдээлэл хүргэсэн.</p> <p><u>Үр сорт, үрийн аж ахуйн чиглэлээр:</u> Холбооны сортын агентлагийн төлөөлөгч, газрын дарга Др. Фройденштайн Монгол улсад ирж ажиллахдаа ХХААЯ, Дархан-Уул аймгийн УГТХ, үр үржүүлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзаж, Дархан-Уул аймгийн Орхон сум, Сэлэнгэ аймгийн Номгонд байрлалтай сорт сорилтын станцуудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсан. Дархан-Уул аймгийн УГТХ дээр “Сорт сорилтын салбарын удирдлага, зохион байгуулалт, чиг үүрэг, хүний нөөц болон техникийн хангамж” сэдвээр сургалт, семинар зохион байгуулсан. Тус сургалтад УГТХ, ХААИС-ийн судлаачид, МХЕГ-ын мэргэжилтнүүд буюу Улсын сорт сорилтын зөвлөлийн гишүүд болон үр үржүүлэгч ААН-ийн төлөөллүүд байлаа. Др. Фройденштайн монголын сорт сорилтын салбарын нөхцөл байдалтай танилцаад германы сорт сорилтын салбаруудад ашиглаж байсан гэхдээ цаашид ашиглах боломжтой техник, тоног төхөөрөмжийг хэрэв монголын тал шаардлагатай гэж үзвэл буцалтгүй тусламж болгон өгөхөд бэлэн байгаагаа илэрхийлсэн. Монголын тал түүнийг нэн</p>

<p>байгуулах. (жилд 3-4 удаагийн үйл ажиллагаанд хамгийн багадаа 200 гаруй салбарын мэргэжилтнүүдийг хамруулна).</p>	<p>хэрэгцээтэйг тэмдэглээд уналтад ороод байгаа сорт сорилтын салбарыг эргэн сэргээхэд тэдгээр техник, тоног төхөөрөмж маш чухал болохыг дурдлаа. Мөн УГТХ-ийн эрдэм шинжилгээний хоёр ажилтанг германы сорт сорилтын салбарт дадлагажуулахаар тохиролцсон.</p> <p><u>Тогтвортой хөрс ашиглалтын чиглэлээр:</u> Төслөөс ХХААХҮЯ, ХААИС болон УГТХ-тэй хамтран “Монгол орны газар тариалангийн хөрсний элэгдэл, доройтол – шийдвэрлэх арга замууд” сэдэвт зөвлөгөөнийг 2016 оны 10 сард зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд ХААИС, УГТХ, Шинжлэх ухааны академийн судлаачид нийт 8 мэргэжлийн илтгэл тавьж оролцсон бол Герман, Австри, Киргиз улсын хөрс судлаачид 3 мэргэжлийн илтгэл тавьж оролцлоо. Түүнчлэн тус зөвлөгөөнд салбарын бодлого боловсруулагчид, эрдэм шинжилгээний байгууллагуудын судлаачид, холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөгчид зэрэг нийт 60 гаруй салбарын мэргэжилтнүүдийг хамрууллаа. Уг зөвлөгөөнөөр хөрс хамгаалах чиглэлээр боловсруулагдсан хууль эрхзүйн орчны хүрээнд газар тариалангийн бүс нутагт хийж, хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлох гол зорилготой байв. 2016 оны 11 дүгээр сарын 31-нд Дархан хотод, 12 дугаар сарын 01-нд Улаанбаатар хотноо “Тариалангийн талбайн хөрсийг бордох арга технологи” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Тус сургалтад төв, баруун, зүүн бүсийн аймгуудын ХААГ-уудын мэргэжилтэнүүд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын төлөөлөгчид, тариалан эрхлэгч ААН-ийн төлөөлөл зэрэг 220 гаруй оролцогчдыг хамруулсан. Хөрсийг хамгаалахгүйгээр арвин ургац авах боломжгүй гэдгийг суралцагсад ойлголт авсан, мөн 30 гаруй жил тус салбарт ажилласан герман зөвлөх Хорст Бунгегийн аливаа үйлдвэрлэлд эдийн засгийн нарийн тооцоо, судалгаа, зардлын бүртгэл, тэмдэглэл, талбайн түүх хөтлөлт чухал болохыг сургалтанд оролцогчдод заасан.</p> <p><u>Тариалангийн даатгалын чиглэлээр:</u> Төслийн төлөөлөл 2016 оны 06 дугаар сараас Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж, бусад орны туршлага судлах болон боловсруулсан хуулийн төсөлд герман мэргэжилтний саналыг тусгаж ажилласан.</p> <p>Дэд сайд Ж.Сауле ахлагчтай ХХААХҮЯ-ны төлөөлөгчид 2016 оны 11 сард “Тариалангийн даатгал болон малын халдварт өвчинтэй тэмцэх арга замууд” сэдэвт тус танилцах аялалд хамрагдсан. ХБНГУ-ын Ханновер хотноо 2 жил тутам зохион байгуулагддаг мал аж ахуйн олон улсын EuroTier үзэсгэлэн яармагийн үйл ажиллагаатай танилцаж, Мюнхены давхар даатгал, Ханноверын давхар даатгал, Нэгдсэн Хагел зэрэг германы даатгалын компаниудын төлөөлөгчидтэй уулзалт, ярилцлага хийж, Холбооны сортын агентлагтай 2017 онд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаануудын төлөвлөгөөг боловсруулан, Нийдерсанхсен мужийн хэрэглэгчдийн эрх ашиг, хүнсний аюулгүй байдлын газартай уулзалт зохион байгуулж малын халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замуудын талаар харилцах туршлага солилцсон. Тус аяллын зорилго нь тариалангийн даатгал болон малын халдварт өвчинтэй тэмцэх арга замуудын</p>
--	--

		<p>талаар харилцан туршлага солилцож, холбогдох байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэхэд оршиж байлаа.</p> <p>2016 оны 12-р сарын 20-ны өдөр ХАА-н салбарт учирч буй эрсдэл, түүнийг бууруулах арга зам, мөн салбарын даатгалын өнөөгийн байдлын талаар хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх бодлого тодорхойлох, эрх зүйн орчинг сайжруулах, талуудын оролцоог идэвхижүүлэх, хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог шинэчлэх зорилго бүхий "Хөдөө аж ахуйн даатгалын бодлого, тогтолцооны шинэчлэл" хэлэлцүүлэгийг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Сангийн яам, ХХААХҮЯ, түүний газар, хэлтсүүд, Санхүүгийн зохицуулах хороо, Хан-Уул дүүргийн ЗДТГ, ХААИС, ХААДД ХК, тариалангийн компаниуд болон ТББ-ын төлөөллүүд оролцсон. ХШҮ-100 %</p>
	<p>Үр дүн 3. Төсөл нь төслийн хэлэлцэгч талуудыг мэргэжлийн чухал мэдээ мэдээлэл, судалгаагаар хангана.</p> <p><u>Шалгуур үзүүлэлтүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> • Төслийн хоёрдугаар үе шатны төгсгөлд төслийн цахим хуудаст хандалтын тоо 15 %-иар өснө (2017 оны эхний улиралд цахим хуудаст хандалтын тоог суурь үзүүлэлтээр авч үзнэ). • Жилд холбогдох сэдвүүдээр 2-оос доошгүй удаагийн судалгааны ажил хийх • Бодлогын болон шинжлэх ухааны салбарын мэргэжлийн сүлжээ үүсгэх; • Тариаланчдад зориулсан 2-оос доошгүй удаагийн үндэсний хэмжээний мэдээллийн үйл ажиллагааг мэргэжлийн мэдээ мэдээллээр хангах байдлаар дэмжиж ажиллах 	<p><u>Цахим хуудсын шинэчлэл:</u> Төслийн цахим хуудсыг шинэчлэх ажил хийгдсэн (www.dmkn.de/mn). Тус цахим хуудсаас төслийн танилцуулга, төлөвлөсөн болон гүйцэтгэсэн ажлуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.</p> <p><u>Судалгааны чиглэлээр:</u> Төслийн хоёрдугаар үе шат эхэлж буйтай холбогдуулан Суурь судалгааг хийлээ. Тус судалгаа 2 бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт Монголын орны газар тариалангийн салбарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсэн:</p> <ul style="list-style-type: none"> – Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, – Газар тариалангийн салбарын хууль эрхзүйн орчин, – Үр сорт, үрийн аж ахуйн салбарын дүн шинжилгээ, – Тогтвортой хөрс ашиглалт, хамгааллын чиглэлээр хийсэн ажлуудын дүн шинжилгээ, – Тариалангийн даатгалын орчин, дүн шинжилгээ, – Төслийн үйл ажиллагааны чиглэлд зөвлөмж боловсруулах зэрэг агуулгыг багтаасан болно. <p>2016 оны 10-12 сард "Ургамал хамгааллын бодис, бордооны хэрэглээ, эрэлт, нийлүүлэлтийн талаарх зах зээлийн судалгаа"-г ХААИС-ийн судлаачид болон германы зөвлөх хамтран гүйцэтгэв. Тус судалгааны зорилго нь Ургамал хамгааллын бодис, Бордооны эрэлт, нийлүүлэлтэд үнэлгээ өгөх. Тариаланч ургамал хамгааллын бодис болон бордоо ашиглахдаа юуг голчлон анхаардаг вэ?, ямар үед бордоо хэрэглэж, мөн хэрэглэхгүй байгааг олж тогтоох, судалгаанаас гарсан үр дүн дээр тулгуурлан, бордооны зөв зохистой хэрэглээний талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагаануудад зөвлөмж боловсруулахад оршсон. ХШҮ-90 %</p> <p><u>Мэргэжлийн харилцаа холбоо, сүлжээний чиглэлээр:</u> Төслөөс герман, монголын төр, хувийн хэвшил болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд болон Монголд ХАА-н чиглэлээр хэрэгжиж буй донор байгууллагуудтай холбоо тогтоон тодорхой сэдвүүдээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, Холбооны сортын</p>

		<p>агентлагтай үр сорт, үрийн аж ахуйн чиглэлээр, Халле хотын Мартин Лютерын их сургуультай тогтвортой хөрс ашиглалт, хамгаалалт чиглэлээр, Лайбниц хотын Хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн /ИАМО/, олон улсын түвшинд үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын болон давхар даатгалын компаниудтай тариалангийн даатгалын чиглэлээр, түүнчлэн Олон улсын цөмийн энергийн агентлагийн хүнс, хөдөө аж ахуйд цөмийн энергийг ашиглах хэлтэс /IAEA/, Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар зэрэг байгууллагуудыг дурдаж болно.</p> <p>Түүнчлэн төслийн дэмжлэгтэйгээр “Төв азийн хөрс судлалын нийгэмлэг” –ийг байгуулах хурлыг зохион байгууллаа. Тус хуралд Австри улсын Вена хотод байрлах Олон улсын цөмийн энергийн агентлаг, ХБНГУ-ын Халле хотын Мартин Лютерын их сургууль, Киргиз улсын Нарин хотын их сургууль, ХААИС, МУИС, ШУА-ийн болон ТББ-ын төлөөлөгчид оролцсон болно.</p> <p>ХШҮ-100 %</p> <p><u>Мэдээллийн үйл ажиллагааны чиглэлээр:</u> Тогтвортой хөрс хамгаалал, ашиглалт чиглэлээр 20 минутын телевизийн нэвтрүүлгийг бэлтгэн олон удаагийн давтамжтайгаар нийтэд хүргэсэн. Тус нэвтрүүлэгт Монгол орны хөрсний өнөөгийн байдал, учирч буй бэрхшээл, шийдвэрлэх асуудлуудын талаар мэргэжлийн судлаач, эрдэмтдийн судалгаа, санал дүгнэлтийг багтаасан болно.</p> <p>Үүний зэрэгцээ олон нийтийн телевизээр ярилцлага, мэдээ хэлбэрээр газар тариалангийн орчин үеийн, дэвшилтэт тариалалтын технологи, шинэ мэдээ мэдээллийг хүргэсэн болно.</p> <p>“Хөрс боловсруулалт, бордооны зүй зохистой хэрэглээ” сэдэвт үйлдвэрлэгчдэд зориулсан хялбаршуулсан технологийн зөвлөмж гарын авлагыг боловсруулж байна.</p> <p>ХШҮ-90 %</p>
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Төсөл, МУ-ын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хоорондын хамтын ажиллагаа</p> <p>Төслийн нэгж ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Стратегийн бодлого, төлөвлөлтийн газартай маш ойр, нягт хамтран ажиллаж байгааг онцлох нь зүйтэй. Төслийн хоёрдугаар шатны анхны Удирдах хорооны хурлыг 2016 оны 11 сарын 15-нд ХБНГУ-ын Ханновер хотод зохион байгуулсан бөгөөд тус хуралд ХХААХҮ-ийн дэд сайд Ж. Саулегээр ахлуулсан төлөөлөгчид оролцсон. Энэхүү Удирдах хорооны хурлаар төслийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж баталж, яамны холбогдох газар, хэлтсүүдтэй хамтран хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p> <p>Төслийн хүрээнд зохион байгуулж буй сургалт семинар, хурал зөвлөгөөн, хэлэлцүүлгүүд нь ХХААХҮЯ-ны хэрэгцээ шаардлагад тулгуурласан байдаг бөгөөд яамны холбогдох газар, хэлтэс хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр төрөөс баримтлаж буй бодлого, УИХ-аар хэлэлцүүлж, батлуулахаар боловсруулсан хууль, тогтоомжийн төслүүд, шинээр болон шинэчлэн батлагдсан хуулиуд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж, оролцогчдын саналыг авч, ажилдаа тусган ажилладаг.</p> <p>Салбарын удирдах болон мэргэжлийн ажилтнуудад зориулсан мэргэшүүлэх, давтан сургалтууд</p>

	<p>2016 оны 5 сарын 28-аас 6 сарын 4-ний хооронд ХБНГУ-д “Таримал ургамлын үр, сорт, үрийн аж ахуй”-н чиглэлээр танилцах аялал зохион байгуулав. Тус аяллын бүрэлдэхүүнд ХХААХҮЯ, УГТХ-ийн холбогдох мэргэжилтэнүүд хамрагдан Европын холбоо, ХБНГУ-д сортын сорилт, баталгаажуулалт, бүртгэл, зохиогчийн эрхийг хэрхэн хамгаалдаг талаар хууль эрхзүй, төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, салбарын тогтолцооны талаар танилцуулга сонсож, сорт сорилтын станцуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан болно. Төслөөс санаачлан ХХААХҮЯ, ХААИС болон Аймгийн ЗДТГ-тай хамтран “Тогтвортой хөдөө аж ахуй” сэдэвт 2 өдрийн сургалтыг 2016.03.09-10-нд Дорнод аймгийн Чойбалсан хотод зохион байгуулсан. Тус сургалтад УИХ-аар шинэчлэн батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, эрх зүйн талаар танилцуулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл, төрийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны төсөл, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авах, газар тариалангийн үйлдвэрлэл дэх хөрс хамгаалал, таримлын сэлгээнд тэжээлийн таримал тариалах технологи, махны үүлдрийн үхрийн аж ахуйн технологи сэдвүүд багтсан болно. Энэ удаагийн сургалтад Дорнод аймгийн ЗДТГ, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг, сумдын агрономи, орон нутгийн газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөллүүд зэрэг нийт 60 гаруй хүмүүс хамрагдсан бөгөөд ийнхүү алслагдсан бүс нутагт шинэ мэдээ, мэдээлэл хүргэсэн нь уг сургалтын гол үр дүн байлаа. Оролцогчид тус сургалтад өндөр ач холбогдол өгч, маш идэвхитэй хамрагдсан.</p> <p>Төслөөс ХХААХҮЯ, ХААИС, УГТХ-тэй хамтран 2016 онд газар тариалангийн хөрс хамгаалал, хөрс бордох технологи, хөдөө аж ахуйн салбарын эрсдлийн менежмент, даатгалын тогтолцоо, үр, сортын салбарын хүний нөөц, техник, тоног төхөөрөмж зэрэг сэдвүүдээр бодлогын зөвлөгөө өгөх, сургалт семинар, зөвлөгөөн, танилцах аяллыг амжилттай зохион байгуулсан. Эдгээрт давхардсан тоогоор 420 гаруй оролцогчид хамрагджээ.</p> <p>Төслийн туршилт, судалгааны ажлууд</p> <p>Төслийн нэгдүгээр үе шатанд эхлүүлсэн германы төмсний сортуудын судалгааны ажлыг хуучин загвар ААН болох “Элит-Үр” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Хушаат сумд байрлах талбайд туршиж, хэмжилт судалгаа хийх судлаачийг дэмжиж ажиллалаа. Тус судалгааны ажлын дүнд 2013 оноос нийт 34 сорт туршигдсанаас 4 сортыг шалгаруулан Улсын сорт сорилтод сорьж байна. Эндээс шалгарвал ирээдүйтэй сортоор батлагдах болно.</p> <p>Төсөл, ХААИС-ийн хамтын ажиллагаа</p> <p>ХААИС болон түүний салбар дээд сургуулиудын эрдэмтэн багш, судлаачидтай хамтран мэргэжлийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Тухайлбал, “Монгол орны газар тариалангийн хөрсний элэгдэл, доройтол – шийдвэрлэх арга замууд” зөвлөгөөн, “Тариалангийн талбайн хөрсийг бордох арга технологи” сэдэвт сургалт, “Ургамал хамгааллын бодис, бордооны хэрэглээ, эрэлт,</p>
--	---

		<p>нийлүүлэлтийн талаарх зах зээлийн судалгаа” сэдэвт судалгааны ажил, "Хөдөө аж ахуйн даатгалын бодлого, тогтолцооны шинэчлэл" хэлэлцүүлгийг тус тус дурдаж болно.</p> <p>Түүнчлэн төслөөр дамжуулан ХААИС болон ХБНГУ-ын ДОЙЛА Нийнбург сургалтын төв хамтран ажиллах гэрээ байгуулан тус гэрээний дагуу мэргэжлийн ангийн 7 оюутан залуусыг орчин үеийн ХАА-н фермд 6 сарын үйлдвэрлэлийн дадлага хийлгэж, дэвшилтэт техник, технологитой газар дээр нь танилцуулсан нь төслийн нэг үр дүн билээ. Дараагийн ээлжийн оюутнууд хэлний бэлтгэлд хамрагдан бэлтгэлээ хангасан бөгөөд 2017 оны 4 сарын эхээр Герман руу явах болно.</p> <p>Түүнчлэн ХААИС-ийн харьяа Иноваци, бизнес хөгжлийн төвтэй хамтран "Хөдөө аж ахуйн даатгалын бодлого, тогтолцооны шинэчлэл" хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэд хэдэн сургалтын хүрээнд хамтран ажилласан.</p> <p>Төсөл, УГТХ-ийн хамтын ажиллагаа</p> <p>Төслийн үндсэн чиглэлүүд болох таримал ургамлын үр, сорт, үрийн аж ахуй болон тогтвортой хөрс хамгаалал, ашиглалтын чиглэлүүдээр УГТХ-тэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, дээр дурдсан “Монгол орны газар тариалангийн хөрсний элэгдэл, доройтол – шийдвэрлэх арга замууд” зөвлөгөөн, “Тариалангийн талбайн хөрсийг бордох арга технологи” сэдэвт сургалтаас гадна “Сорт сорилтын салбарын удирдлага, зохион байгуулалт, чиг үүрэг, хүний нөөц болон техникийн хангамж” сэдэвт семинар, “Хөрс боловсруулалт, бордооны зүй зохистой хэрэглээ” сэдэвт үйлдвэрлэгчдэд зориулсан гарын авлагыг боловсруулж байна.</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан.				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (тухайн жилийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Үр дүн	Үр дүн 1	Үр дүн 2	Үр дүн 3
		94.4	Хувь	90 %	100 %	93.3 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				